



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энцоодол
Утас: 99057478 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 99079641 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
5.1 Төлбөрийн акт	10
5.2 Албан шаардлага	10
5.3 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
БХС	Байаль хамгаалах сан
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СЗДТГ	Сумын засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2024.03.24 № 381

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Х.УНДРАХБАЯР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган аймгийн Орхон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчил, түүний санхүүгийн тайлан, тодруулгад үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган аймгийн Орхон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар 2.9 сая, батлагдаагүй 51.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн,
2. ЖДҮДС-ийн зээлийн эргэн төлөлтийг үндсэн зээл, хүүгийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнаагүй,
3. ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалт дансанд 12.2 сая төгрөгийн зээн холбогдогч нь тодорхойгүй он дамжсан олон жил болсон авлага, Сум хөгжүүлэх сангийн үндсэн хөрөнгийн тайланд 2.5 сая төгрөгийн программ хангамж тус тус бүртгэлтэй,
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй,

632502769

5. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 7 төсвийн шууд захирагч, 5 тусгай сангийн нийт 12 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн сайдын "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх" 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам нь 2025 оны 02 дугаар тушаалаар хүчингүй болсон боловч, тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу хуучин журмыг мөрдөж ажиллах чиглэлийг өгсөн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хэтрүүлэн шийдвэр гаргаснаас төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны XXI дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлуулж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын 2 хөтөлбөрийг 2 шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх засаглалын 5 хөтөлбөрийг 8 шалгуур үзүүлэлтээр хэрэгжилтийг тооцож ажиллахаар баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12- р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		967,103.7	1,579,555.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	559,984.8	1,152,999.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	243,176.5	249,826.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	37,119.9	49,907.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	126,822.5	126,822.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,251,295.8	4,283,547.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,251,295.8	4,283,547.5
39200	Биет хөрөнгө		1,525,991.9	2,558,743.6
39300	Биет бус хөрөнгө	13	1,725,303.9	1,724,803.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,218,399.5	5,863,103.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	4,946.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	0.0	4,946.1
41300	Өглөг	17а, 17б	0.0	4,946.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,218,399.5	5,858,157.3
51	Засгийн газрын хувь оролцоо		4,218,399.5	5,858,157.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		490,242.7	1,974,397.1
51200	Хуримтлагдсан үр дүн		3,208,658.3	3,364,261.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		519,498.5	519,498.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,218,399.5	5,863,103.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,171,140.1	4,551,140.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		615,958.0	903,629.4
110	Орлогын албан татвар		201,969.7	477,545.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		201,969.7	477,545.4
113	Хөрөнгийн албан татвар		108,391.1	130,258.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		305,597.2	295,825.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,687,353.4	1,285,951.5
120	Нийтлэг татварын бус орлого		1,687,353.4	1,285,951.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		867,828.7	2,361,559.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,375,638.5	1,639,629.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,375,638.5	1,639,629.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,364,731.7	1,606,040.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		512,630.3	717,770.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		63,045.6	89,961.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		131,685.8	376,282.1

2104	Хангамж, бараа материалын зардал	43,716.6	59,421.3
2105	Нормативт зардал	320.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,366.2	23,711.2
2107	Томилолт, зочны зардал	9,882.5	12,824.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	636.3	15,548.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	585,448.5	310,520.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,906.8	33,589.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,795,501.7	2,911,510.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	366,327.3	1,271,752.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,429,174.3	1,639,757.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,789,480.0	2,789,480.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(254.8)	(254.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,789,225.2	2,789,225.2
4	Тайлант үеийн үр дүн	1,429,174.3	1,429,174.3
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,218,399.5	4,218,399.5
6	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,218,399.5	4,218,399.5
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,484,154.4)	(1,484,154.4)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,734,245.1	2,734,245.1
9	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,484,154.4	1,484,154.4
10	Тайлант үеийн үр дүн	1,639,757.8	1,639,757.8
11	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,858,157.3	5,858,157.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,647,740.9	3,426,619.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	615,958.0	903,629.4
110	Орлогын албан татвар	201,969.7	477,545.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	201,969.7	477,545.4
113	Хөрөнгийн албан татвар	108,391.1	130,258.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	305,597.2	295,825.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	48,702.8	29,590.3
1181	Газрын төлбөр	229,017.2	236,032.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,877.3	30,202.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,954.2	161,431.1
120	Нийтлэг татварын бус орлого	163,954.2	161,431.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	867,828.7	2,361,559.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,175,850.4	1,438,682.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,175,850.4	1,438,682.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,165,298.6	1,405,093.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,397.9	712,824.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,045.6	89,961.5

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,685.8	376,319.2
2104	Хангамж, бараа материалын зардал	41,810.7	58,290.3
2105	Нормативт зардал	600.5	883.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,366.2	23,865.7
2107	Томилолт, зочны зардал	9,882.5	12,824.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,449.3	29,788.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	371,060.2	100,336.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,551.8	33,589.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	471,890.5	1,987,937.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	380,365.5	1,296,638.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	380,365.5	1,296,638.2
2200	Дотоод эх үүсвэрээр	380,365.5	1,296,638.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(380,365.5)	(1,296,638.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(939.7)	(98,285.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	939.7	98,285.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	90,585.2	593,014.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	469,399.6	559,984.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	559,984.8	1,152,999.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,089,784.9	2,797,067.7	1,292,717.2	68.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,651,627.9	1,427,030.0	224,597.9	86.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,618,020.6	1,393,622.7	224,397.9	86.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	817,447.6	712,824.7	104,622.9	87.2
210101	Үндсэн цалин	426,738.1	408,569.1	18,169.0	95.7
210102	Нэмэгдэл	336,709.5	261,634.1	75,075.4	77.7
210104	Урамшуулал	54,000.0	42,621.5	11,378.5	78.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,181.0	89,961.5	12,219.5	88.0
210201	Тэтгэврийн даатгал	69,483.1	61,010.5	8,472.6	87.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,174.4	7,177.7	996.7	87.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,087.2	3,852.7	234.5	94.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,087.2	3,584.1	503.1	87.7
210205	Эрүүл мэндийн даатгал	16,349.1	14,336.5	2,012.6	87.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	378,946.1	376,319.2	2,626.9	99.3
210301	Гэрэл, цахилгаан	24,636.9	23,212.2	1,424.7	94.2
210302	Түлш, халаалт	354,059.2	353,057.1	1,002.1	99.7
210303	Цэвэр, бохир ус	250.0	50.0	200.0	20.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,550.0	32,663.7	2,886.3	91.9
210401	Бичиг хэрэг	5,700.0	5,640.6	59.4	99.0

210402	Тээвэр, шатахуун	19,050.0	19,008.0	42.0	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,300.0	3,618.4	681.6	84.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,200.0	2,710.4	1,489.6	64.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300.0	1,686.3	613.7	73.3
2105	Нормативт зардал	900.0	883.7	16.3	98.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900.0	883.7	16.3	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,100.0	37,065.6	1,034.4	97.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,500.0	20,418.6	81.5	99.6
210604	Урсгал засвар	17,600.0	16,647.0	953.0	94.6
2107	Томилолт, зочны зардал	15,500.0	12,280.1	3,219.9	79.2
210701	Гадаад албан томилолт	6,000.0	6,000.0	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	9,500.0	6,280.1	3,219.9	66.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,362.1	28,654.1	78,708.0	26.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,535.8	26,850.4	78,685.4	25.4
210803	Даатгалын үйлчилгээ	296.3	296.3	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	420.0	407.9	12.1	97.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110.0	99.5	10.5	90.5
210807	Газрын төлбөр	1,000.0	1,000.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,033.8	102,970.1	19,063.7	84.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,062.5	91,907.6	17,154.9	84.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,971.3	11,062.5	1,908.8	85.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,607.3	33,407.3	200.0	99.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,607.3	33,407.3	200.0	99.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,907.3	31,907.3	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700.0	1,500.0	200.0	88.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,085,847.0	1,271,752.7	814,094.3	61.0
223001	Бусад хөрөнгө	2,085,847.0	1,271,752.7	814,094.3	61.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	352,310.0	98,285.0	254,025.0	27.9
230001	Эргэж төлөгдөх зээл	352,310.0	98,285.0	254,025.0	27.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,089,784.9	3,180,160.4	909,624.5	77.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,313,093.7	3,069,865.2	243,228.5	92.7
320001	Орон нутгийн төсвөөс	1,729,040.4	1,547,590.0	181,450.4	89.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,584,053.3	1,522,275.2	61,778.1	96.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	776,691.2	110,295.2	666,396.0	14.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	219,343.5	110,295.2	109,048.3	50.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	557,347.7	0.0	557,347.7	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52	48	4	92.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	23	2	92.0
620001	Удирдах ажилтан	9	9	-	100.0

620002	Гүйцэтгэх ажилтан	12	10	2	83.3
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	23	2	92.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	8	2	80.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,538.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,538.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,356.2
2104	Хангамж, бараа материалын зардал	25,981.6
210402	Тээвэр, шатахуун	6,381.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,496.7
210604	Урсгал засвар	5,496.7
2107	Томилолт, зочны зардал	544.0
210702	Дотоод албан томилолт	544.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,134.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,134.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,200.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	181.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	181.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,538.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,538.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,264.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,774.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,500.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 7 төсвийн захирагч, орон нутгийн төсвийн орлогын дансыг хамруулахаас сумын ЗДТГ-т хязгаарлалттай дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 196.6 сая төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс, 12.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 192.3 сая төгрөгийн 4 албан шаардлага, 35.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 5,695.7 сая төгрөгийн 7 алдаа¹ зөрчил илэрснээс, 40.3 сая төгрөгийн 3 алдаанд 3 зөвлөмж, 2.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 51.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 4,098.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга тайлан, тооцоо нийлсэн акт, үлдэгдлийн баталгааг ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрдэл хангагдаагүй ТТЗ-ийн санхүүгийн тайланд бэлтгэсэн 25.7 сая, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй 12.2 сая, сум хөгжүүлэх сангийн үндсэн хөрөнгөд 2.5 сая төгрөгийн албан хаагчийн ашиглалтын бүртгэл карт байхгүй алдаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж ажиллах 3 зөвлөмж өгч ажиллалаа.

5.1 Төлбөрийн акт

Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар 2.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэхь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6 дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд 51,187.9 мянган төгрөгийг 3 арга хэмжээг санхүүжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэхь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5 дахь заалтыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

үндэслэн зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоолоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: ЖДҮДС-ийн зээлийн эргэн төлөлтийн хүүгийн орлогыг НБББББ дагуу бүртгээгүй нь аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар баталсан НБББББ, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах.

1.2 Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн орлогын тогтоолыг батлахдаа орон нутгийн төсвийн орлого зардлын дээд хэмжээг баталсан дүн зөрүүтэй, алдаатай баталсан нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхдээ үндэслэх эрх зүйн актыг баримтлан гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
ИТХ													
ЗДТГ													
ХХСан													
ОНХСан													
БХСан													
ЖДҮДСан													
ТТЗ	3	40.3				3	40.3			3	40.3	3	40.3
Дүн	3	40.3				3	40.3			3	40.3	3	40.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	0.5					2	0.5				
ЗДТГ	9	196.1	3	2.4	3	158.8	3	34.9				
ХХСан												
ОНХСан	4	43.1	3	9.6	1	33.5						
БХСан												
ЖДҮДСан												
ТТЗ	4	4,143.9	1	2.9	1	51.2	2	4,089.8				
Дүн	15	4,383.6	6	14.9	4	243.5	7	4,125.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ								
ЗДТГ								
ОНХС								
ТТЗ	1	1,271.8					1	1,271.8
Дүн	1	1,271.8					1	1,271.8



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 01/231

Булган сум

А0670283

БҮА-2025/001/НА-ЕТА-773

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Орхон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд 2,920,000.00 (хоёр сая есөн зуун хорин мянга) төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Цалингийн зардлаас албан хаагчдад зориулалт бусаар олгосон 2,920,000.00 (хоёр сая есөн зуун хорин мянга) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр), Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Жавхлан) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТОР



Ж.ЭНХЦООДОЛ
Г.ЦЭРЭНЛХАМ

637595781



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 01/160

Булган сум

А06.70253 ЗУА-2025/001/НА-СТА-ТБЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Орхон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд батлагдаагүй 51,187,906.00 (тавин нэгэн сая нэг зуун наян долоон мянга есөн зуун зургаа) төгрөгийн 3 арга хэмжээг санхүүжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдээгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.4-д "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Батлагдаагүй арга хэмжээг санхүүжүүлж, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр), Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Жавхлан) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

6317144793
80048 3198269

ЖЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

832504572



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 02/161

Булган сум

А0670253 ВУА-2025/001/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Орхон сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 171 мэдээлэл мэдээлэхээс 167 мэдээллийг хугацаандаа, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайлан, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй, оруулах байхгүй гэсэн төлвөөр мэдээлсэн, хавсралт файлыг мэдээлсэн боловч нотлох баримтыг тухайн мэдээллийг хавсралт бүрээр мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 7 дугаар зүйлийн 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ийн 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-д заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

032504568

1.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр), Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Жавхлан) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР



Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ